



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 35

Мөрөн

Г.Мөнхзаяа, Д.Батчулуун нарыг төрийн
жинхэнэ албаны нөөцөд бүртгэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 17, 59 дүгээр тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөр эрхлэлт, жижиг дунд үйлдвэр, сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн Г.Мөнхзаяа нь төрийн албанаас түр чөлөөлөгдсөн тул Төрийн албаны тухай хуульд заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалаас түр чөлөөлөгдсөн албан хаагчийн нөөцөд бүртгэсүгэй.


2. Хөвсгөл аймгийн Авто тээврийн газар татан буугдаж, төрийн байгууллага татан буугдсан үндэслэлээр Авто тээврийн газрын даргын албан тушаалаас чөлөөлөгдсөн Дамдины Батчулууныг Төрийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.4-т заасан болон Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу цэргийн тэтгэвэр тогтоолгож /дээд офицер, офицер, ахлагч/ төрийн жинхэнэ албан тушаалаас чөлөөлөгдсөн иргэний нөөцөд бүртгэсүгэй.

3. Г.Мөнхзаяагийн төрийн жинхэнэ албаны нөөцийн хугацааг 3 жилээр, Д.Батчулууны төрийн жинхэнэ албаны нөөцийн хугацааг тэтгэвэр тогтоолгох насанд хүртэл хугацаагаар тус тус тогтоосугай.

4. Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн иргэдийн бүртгэлийг бүртгэл хөтлөх загварын дагуу бүртгэж, хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (С.Энхзаяа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (С.Энхзаяа)-д даалгасугай.

ДАРГА



Х.ГАН-ОЧИР